



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 09 сарын 13 өдөр

Дугаар А/382

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1/а/, 29.2 дахь заалт, Ахмад настны тухай хуулийн 13.4, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн ээлжит 3 дугаар хуралдааны 01 дүгээр тогтоол, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны 65 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Ач санах” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор баг бүрийн ахмад настнуудад чиглэсэн зорилтот үйл ажиллагаанд Баян-Өндөр суманд 8736000 төгрөгийн, Жаргалант суманд 1248000 төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлж, хуваарилалтыг хавсралтаар баталсугай.

2.Дэмжлэгт шаардагдах 10 000 000 /Арван сая/ төгрөгийг “Баг бүрийн ахмад настнуудад чиглэсэн зорилтот үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх арга хэмжээний зардал”-аас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.


3.Баг бүрийн ахмад настнуудад чиглэсэн зорилтот үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /н.Бумансор/-т, үйл ажиллагааг тухайн багаас сонгогдсон аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нартай хамтран өндөр түвшинд зохион байгуулахыг Баян-Өндөр сум /н.Ганцогт/, Жаргалант сум /н.Зоригтбаяр/ нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017 оны
09 дүгээр сарын 18-ны өдрийн
532 дугаар захирамжийн хавсралт



**БАГ БҮРИЙН АХМАДАД ЧИГЛЭСЭН ЗОРИЛТОД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
САНХҮҮЖИЛТИЙН ХУВААРЬ**

Баян-Өндөр сум		
№	Багийн нэрс	Мөнгөн дүн /төгрөг/
1	Зэст баг	416 000
2	Оюут баг	416 000
3	Уурхайчин баг	416 000
4	Хүрэнбулаг баг	416 000
5	Уртбулаг баг	416 000
6	Согоот баг	416 000
7	Дэнж баг	416 000
8	Бүрэнбүст баг	416 000
9	Шанд баг	416 000
10	Наран баг	416 000
11	Цагаанчулуут баг	416 000
12	Булаг баг	416 000
13	Баянцагаан баг	416 000
14	Говил баг	416 000
15	Рашаант баг	416 000
16	Эрдэнэ баг	416 000
17	Баянбулаг баг	416 000
18	Их залуу баг	416 000
19	Даваат баг	416 000
20	Уртын гол баг	416 000
21	Яргуйт баг	416 000
Жаргалант сум		
1	Дулаан Уул	416 000
2	Жаргалант	416 000
3	Улаан толгой	416 000